



ҮНДЭСНИЙ
СТАТИСТИКИЙН
ХОРОО




БАРИЛГА 2021

Улаанбаатар хот
2022 он



ҮНДЭСНИЙ
СТАТИСТИКИЙН
ХОРОО

БАРИЛГЫН САЛБАР ТАНИЛЦУУЛГА 2021 ОН



Улаанбаатар хот
2022 он

ТАНИЛЦУУЛГЫГ БЭЛТГЭН БОЛОВСРУУЛСАН:

Л.Шинэтуяа

ҮСХ-ны ЭЗСГ-ын ХААБОҮСХ-ийн статистикч

ТАНИЛЦУУЛГЫГ ХЯНАСАН:

Б.Батдаваа

ҮСХ-ны дарга

Д.Лхамсүрэн

ҮСХ-ны дэд дарга

Э.Эрдэнэсан

ҮСХ-ны Нэгдсэн статистикийн газрын дарга

А.Дэмбэрэл

ҮСХ-ны ЭЗСГ-ын дарга

Э.Мягмарханд

ҮСХ-ны ЭЗСГ-ын ХААБОҮСХ-ийн дарга

Б.Уянгаа

ҮСХ-ны ЭЗСГ-ын ХААБОҮСХ-ийн ахлах статистикч

МОНГОЛ УЛСЫН ҮНДЭСНИЙ СТАТИСТИКИЙН ХОРОО

Монгол Улс, Улаанбаатар хот
Засгийн газрын III байр,
Бага тойруу - 44, Улаанбаатар -11
Утас: (976-11)-326414, 1900-1212
Факс: (976-11)-324518
Цахим хуудас: www.nso.mn, www.1212.mn
И-мэйл: information@nso.mn

АГУУЛГА

| | |
|---|----|
| ХҮСНЭГТЭН МЭДЭЭЛЛИЙН ЖАГСААЛТ | 2 |
| ЗУРГАН МЭДЭЭЛЛИЙН ЖАГСААЛТ | 3 |
| ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ | 4 |
| ОЙЛГОЛТ, ТОДОРХОЙЛОЛТ | 5 |
| ХАМРАХ ХҮРЭЭ | 7 |
| БАРИЛГЫН САЛБАРЫН ХӨГЖЛИЙН ТҮҮХ | 8 |
| I.БАРИЛГЫН САЛБАРЫН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ..... | 10 |
| I.1 БАРИЛГЫН САЛБАРЫН ЭДИЙН ЗАСАГТ ЭЗЛЭХ БАЙР, СУУРЬ | 10 |
| I.2 БАРИЛГЫН САЛБАРЫН АЖ АХУЙН НЭГЖ, БАЙГУУЛЛАГЫН ТОО..... | 10 |
| I.3 БАРИЛГЫН САЛБАРТ АЖИЛЛАГЧИД | 11 |
| I.4 БАРИЛГЫН САЛБАРТ АЖИЛЛАГЧДЫН ДУНДАЖ ЦАЛИН | 11 |
| I.5 БАРИЛГЫН САЛБАР ДАХЬ ХӨДӨЛМӨРИЙН БҮТЭЭМЖ | 12 |
| I.6 БАРИЛГЫН САЛБАРЫН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ | 13 |
| I.7 БАРИЛГЫН САЛБАРЫН ОСОЛ | 13 |
| II.БАРИЛГА УГСРАЛТ ИХ ЗАСВАРЫН АЖЛЫН ГҮЙЦЭТГЭЛ..... | 15 |
| III.АШИГЛАЛТАД ОРУУЛСАН ҮНДСЭН ФОНД..... | 19 |
| III.1 АШИГЛАЛТАД ОРУУЛСАН ОРОН СУУЦНЫ БАРИЛГА | 19 |
| III.1.1 ИПОТЕКИЙН ЗЭЭЛ | 20 |
| III.2 АШИГЛАЛТАД ОРУУЛСАН ОРОН СУУЦНЫ БУС БАРИЛГА | 21 |
| III.3 МОНГОЛ УЛСЫН АВТО ЗАМЫН СҮЛЖЭЭ | 22 |
| IV.БАРИЛГЫН ЗАРИМ НЭР ТӨРЛИЙН БҮТЭЭГ ДЭХҮҮНИЙ ЗАХ ЗЭЭЛИЙН МЭДЭЭЛЭЛ | 24 |
| IV.1 ЗАРИМ НЭР ТӨРЛИЙН БҮТЭЭГ ДЭХҮҮНИЙ ҮЙЛДВЭРЛЭЛ, ИМПОРТ | 24 |
| IV.2 ЗАРИМ НЭР ТӨРЛИЙН БҮТЭЭГ ДЭХҮҮНИЙ ҮНЭ | 25 |
| V.ДҮГНЭЛТ | 27 |
| АШИГЛАСАН МАТЕРИАЛЫН ЖАГСААЛТ | 28 |
| ХАВСРАЛТ ХҮСНЭГТҮҮД..... | 29 |

ХҮСНЭГТЭН МЭДЭЭЛЛИЙН ЖАГСААЛТ

| | |
|--|----|
| ХҮСНЭГТ 1. АЖИЛЛАГЧИД, нас, хүйсээр, мянган хүн | 11 |
| ХҮСНЭГТ 2. БАРИЛГЫН САЛБАРЫН ААНБ-ЫН ТОО | 29 |
| ХҮСНЭГТ 3. АЖИЛЛАГЧДЫН ТОО | 29 |
| ХҮСНЭГТ 4. БАРИЛГЫН САЛБАРТ ОСОЛДОГЧИД, хүйсээр, ослын хэлбэрээр | 29 |
| ХҮСНЭГТ 5. БАРИЛГЫН САЛБАРЫН НЭМЭГДЭЛ ӨРТӨГ | 29 |
| ХҮСНЭГТ 6. БАРИЛГА УГСРАЛТ, ИХ ЗАСВАРЫН АЖИЛ, дотоод, гадаадын байгууллагаар ... | 30 |
| ХҮСНЭГТ 7. БАРИЛГА УГСРАЛТ, ИХ ЗАСВАРЫН АЖЛЫН БҮТЭЦ, барилгын төрлөөр | 30 |
| ХҮСНЭГТ 8. ДОТООДЫН БАРИЛГЫН БАЙГУУЛЛАГЫН ГҮЙЦЭТГЭСЭН БАРИЛГА УГСРАЛТ, ИХ ЗАСВАРЫН АЖИЛ, бүс, аймаг, нийслэлээр | 31 |
| ХҮСНЭГТ 9. АШИГЛАЛТАД ОРУУЛСАН ҮНДСЭН ФОНД, барилгын төрлөөр | 31 |
| ХҮСНЭГТ 10. АШИГЛАЛТАД ОРУУЛСАН ҮНДСЭН ХӨРӨНГӨ, барилгын төрөл, хүчин чадлаар | 32 |
| ХҮСНЭГТ 11. БАРИЛГЫН ЗАРИМ НЭР ТӨРЛИЙН БҮТЭЭГ ДЭХҮҮНИЙ ҮЙЛДВЭРЛЭЛ | 32 |
| ХҮСНЭГТ 12. БАРИЛГЫН ЗАРИМ НЭР ТӨРЛИЙН БАРААНЫ ИМПОРТ | 32 |
| ХҮСНЭГТ 13. БАРИЛГЫН ЗАРИМ НЭР ТӨРЛИЙН БАРААНЫ ЖИЛИЙН ДУНДАЖ ҮНЭ | 33 |

ЗУРГАН МЭДЭЭЛЛИЙН ЖАГСААЛТ

| | |
|---|----|
| ЗУРАГ 1. ДОТООДЫН НИЙТ БҮТЭЭГДЭХҮҮНИЙ САЛБАРЫН БҮТЭЦ, САЛБАРААР ... | 10 |
| ЗУРАГ 2. БАРИЛГЫН САЛБАРЫН ААНБ-ЫН ТОО, мянган аанб..... | 10 |
| ЗУРАГ 3. БАРИЛГЫН САЛБАРТ ҮЙЛ АЖИЛЛАГАА ЯВУУЛЖ БАЙГАА ААНБ-ЫН БҮСҮҮДЭД ЭЗЛЭХ ХУВЬ..... | 11 |
| ЗУРАГ 4. БАРИЛГЫН САЛБАРТ АЖИЛЛАГЧДЫН ДУНДАЖ ЦАЛИН, мянган төгрөгөөр | 12 |
| ЗУРАГ 5. БАРИЛГЫН САЛБАР ДАХЬ ХӨДӨЛМӨРИЙН БҮТЭЭМЖ, 2015 оны зэрэгцүүлэх үнээр, сая төгрөг | 12 |
| ЗУРАГ 6. БАРИЛГЫН САЛБАРЫН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ, тэрбум төгрөгөөр | 13 |
| ЗУРАГ 7. БАРИЛГЫН САЛБАРТ ОСОЛДСОН ХҮНИЙ ТОО | 13 |
| ЗУРАГ 8. БАРИЛГА УГСРАЛТ, ИХ ЗАСВАРЫН АЖЛЫН ГҮЙЦЭТГЭЛ, тэрбум төгрөгөөр | 15 |
| ЗУРАГ 9. ДОТООДЫН БАРИЛГЫН БАЙГУУЛЛАГЫН ГҮЙЦЭТГЭСЭН БАРИЛГА УГСРАЛТ, ИХ ЗАСВАРЫН АЖЛЫН ХЭМЖЭЭ, улирлаар, тэрбум төгрөгөөр | 15 |
| ЗУРАГ 10. ДОТООДЫН БАРИЛГЫН БАЙГУУЛЛАГЫН ГҮЙЦЭТГЭСЭН БАРИЛГА УГСРАЛТ, ИХ ЗАСВАРЫН АЖЛЫН БҮТЭЦ, хувиар | 16 |
| ЗУРАГ 11. БАРИЛГА УГСРАЛТ, ИХ ЗАСВАРЫН АЖЛЫН БҮТЭЦ, барилгын төрлөөр, хувиар..... | 16 |
| ЗУРАГ 12. БАРИЛГА УГСРАЛТ, ИХ ЗАСВАРЫН АЖЛЫН ГҮЙЦЭТГЭЛ, бүсээр, хувиар | 17 |
| ЗУРАГ 13. АШИГЛАЛТАД ОРУУЛСАН ҮНДСЭН ФОНД, барилгын төрлөөр, хувиар.... | 19 |
| ЗУРАГ 14. АШИГЛАЛТАД ОРУУЛСАН ОРОН СУУЦ, айлын тоо, өртгөөр | 19 |
| ЗУРАГ 15. АШИГЛАЛТАД ОРУУЛСАН ОРОН СУУЦНЫ БАРИЛГА, ИПОТЕКИЙН ЗЭЭЛД ХАМРАГДСАН ИРГЭДИЙН ТОО..... | 20 |
| ЗУРАГ 16. АШИГЛАЛТАД ОРУУЛСАН ОРОН СУУЦ, айлын тоогоор, аймгаар..... | 20 |
| ЗУРАГ 17. АШИГЛАЛТАД ОРУУЛСАН СУРГУУЛЬ, СОЁЛЫН БАРИЛГА, суудлаар..... | 21 |
| ЗУРАГ 18. АШИГЛАЛТАД ОРУУЛСАН ЭМНЭЛЭГ, орны тоогоор | 21 |
| ЗУРАГ 19. АШИГЛАЛТАД ОРУУЛСАН АВТО ЗАМ, км | 22 |
| ЗУРАГ 20. АШИГЛАЛТАД ОРУУЛСАН ГҮҮР, ГҮҮРЭН ГАРЦ, метр..... | 22 |
| ЗУРАГ 21. ЦЕМЕНТИЙН ҮЙЛДВЭРЛЭЛ, ИМПОРТ, мян.тн | 24 |
| ЗУРАГ 22. БАРИЛГЫН БЛОКИЙН ҮЙЛДВЭРЛЭЛ, ИМПОРТ, мян.тн | 24 |
| ЗУРАГ 23. БАРИЛГЫН ЗАРИМ НЭР ТӨРЛИЙН БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ҮЙЛДВЭРЛЭЛ.... | 25 |
| ЗУРАГ 24. БАРИЛГЫН ЗАРИМ НЭР ТӨРЛИЙН БАРААНЫ ЖИЛИЙН ДУНДАЖ ҮНЭ ... | 26 |

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

| | |
|----------|--|
| ААНБ | Аж ахуйн нэгж, байгууллага |
| БР | Статистикийн бизнес регистрийн сан |
| БХБЯ | Барилга, хот байгуулалтын яам |
| ЗТХЯ | Зам тээврийн хөгжлийн яам |
| БХТ | Барилгын хөгжлийн төв |
| ДНБ | Дотоодын нийт бүтээгдэхүүн |
| НҮБ | Нэгдсэн Үндэстний Байгууллага |
| АХБ | Азийн Хөгжлийн Банк |
| МХЕГ | Мэргэжлийн хяналтын ерөнхий газар |
| ҮСХ | Үндэсний Статистикийн Хороо |
| ТЕГ | Татварын Ерөнхий Газар |
| ГЕГ | Гаалийн Ерөнхий Газар |
| МИК | Монголын ипотекийн корпорац |
| ЭЗБТҮАСА | Эдийн засгийн бүх төрлийн үйл ажиллагааны салбарын ангилал |
| ОУНОШБ | Олон Улсын нисэх онгоцны шинэ буудал |
| ХАОСТ | Хүн ам, орон сууцны тооллого |
| БУИЗА | Барилга угсралт, их засварын ажил |

Тэмдэглэгээ

| | |
|----------------|----------------------|
| * | Урьдчилсан гүйцэтгэл |
| м ² | Метр квадрат |
| м ³ | Метр куб |
| ... | Гүйцэтгэл байхгүй |

ОЙЛГОЛТ, ТОДОРХОЙЛОЛТ

Барилгын салбарын статистикийн үзүүлэлтүүдийг дараах ойлголт, тодорхойлолтын хүрээнд мөрддөг.

Барилгын үйл ажиллагаа гэж байгууламжийн зураг төсөл, баримт бичиг боловсруулах, магадлал хийх, барилгын ажил гүйцэтгэх, үе шатны ажилд хяналт тавих, чанар аюулгүй байдлын шинжилгээ хийх, ашиглалтад оруулж, гэрчилгээжүүлэх үйл ажиллагааг ойлгоно.

Барилга байгууламжид орон сууц, иргэн, үйлдвэр, эрчим хүч, харилцаа холбоо, ус, нефтийн барилга, ус суваг, далан хаалт зэрэг байгууламж, түүний инженерийн шугам сүлжээг хамруулж ойлгоно.

Орон сууцны барилга гэж нийт ашигтай талбайг бүхэлд нь эсвэл нийт ашигтай талбайн талаас илүү хувийг орон сууцны зориулалтаар (үлдсэн хувийг өөр зориулалтаар ашиглаж болохуйц байж болно.) хэрэглэж болохуйц байгууламжийг хамруулж ойлгоно. Орон сууцны барилгыг энгийн орон сууц, үйлчилгээтэй орон сууц, гарааштай орон сууц, гарааш, үйлчилгээтэй орон сууц гэж ангилж авч үзнэ. Энэ төрлийн барилгад нэг гэр бүл болон олон гэр бүл амьдарч болохуйц нийтийн сууц, сууцны бие даасан барилга, амины сууц, зарим хэсэг нь худалдаа, үйлчилгээний зориулалттай орон сууцны барилга зэрэг багтана.

Орон сууцны бус барилга гэж тухайн байгууламжийн нийт ашигтай талбайг бүхлээр нь орон сууцны бус зориулалтаар ашиглаж болохуйц эсвэл нийт ашигтай талбайн талаас илүү хувийг орон сууцны бус зориулалтаар ашиглаж болохуйц байгууламжийг ойлгоно. Орон сууцны бус барилгыг үйлдвэрийн, худалдаа, үйлчилгээний, зочид буудлын, эмнэлгийн, сүм хийдийн, сургууль, соёлын, цэцэрлэгийн, спорт, биеийн тамирын, албан конторын, орон сууцны бус бусад (агуулах, гарааш болон бусад) гэж ангилна.

Инженерийн барилга, байгууламж гэж төмөр зам, зам, гүүр, хурдны зам, онгоцны буудлын талбай, усан хангамж, бохирын шугам, далан хаалт, усжуулалтын байгууламж зэрэг барилга угсралтад ангилагддаггүй барилга, байгууламжийн бүх ажлыг хамруулж ойлгоно. Инженерийн байгууламжийг эрчим хүчний, холбооны, төмөр зам, хатуу болон хайрган хучилттай авто зам, сайжруулсан хөрсөн зам, ердийн хөрсөн зам, төмөр бетон гүүр, гүүрэн гарц, модон гүүр, гүүрэн гарц, далан суваг, шугам, бусад зам талбайн ажил гэж ангилна.

Инженерийн дэд бүтэц нь авто зам, төмөр зам, дүүжин зам, газрын доор, дээр байрлах замын байгууламж, бүх төрлийн инженерийн шугам сүлжээ, гамшиг, ослоос урьдчилан сэргийлэх энгийн болон инженерийн хийц, бүтээц бүхий байгууламж юм.

Инженерийн шугам, сүлжээ нь ус хангамж, цахилгаан, дулаан, ариутгах татуурга, цэвэрлэх байгууламж, газрын тос болон төрөл бүрийн хий дамжуулах хоолой, харилцаа холбооны төвлөрсөн байгууламж юм.

Барилга угсралт, их засварын ажил гэж барилга, байшин барих болон инженерийн зориулалтаар зам, гүүр, далан зэрэг инженерийн бусад байгууламжийг барих хэлбэрээр үндсэн хөрөнгийг бий болгох, шинэчлэх, засварлах, өргөтгөхөд чиглэсэн үйл ажиллагааг хамруулж ойлгоно. Их засварын ажилд орон сууцны болон орон сууцны бус барилга, инженерийн барилга байгууламжид хийгдэх бүх төрлийн засварын ажлыг хамруулж ойлгоно.

Буулгалтын ажил гэж ашиглалтын шаардлага хангахгүй болсон, хууль тогтоомж, барилга байгууламжийн норм, нормативын баримт бичгийн шаардлагыг ноцтой зөрчиж баригдсан нь эрх бүхий байгууллагаас тогтоогдсон барилга байгууламжийг бүхэлд нь эсхүл хэсэгчлэн буулгах үйл ажиллагааг ойлгоно.

Гадна тохижилтын ажил гэж барилга байгууламжийн гаднах талбайн ногоон байгууламж, авто зам, зогсоол, явган хүний зам, гарц, оршин суугчдын амрах болон хүүхдийн тоглоомын талбай, уран барилгын жижиг хэлбэр, гэрэлтүүлэг зэргийг барьж байгуулах үйл ажиллагааг ойлгоно.

Үе шатны ажил гэж барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах, барилгын ажил гүйцэтгэх, ашиглалтад оруулах үйл ажиллагаа тус бүрийн технологийн дараалал юм.

Барилгын ажлын гүйцэтгэгч гэж захиалагчтай гэрээ байгуулсны үндсэн дээр барилгын ажлыг гүйцэтгэх эрх бүхий хуулийн этгээд юм. Барилгын ажлыг гүйцэтгэгч ААНБ-ыг өмчийн хэлбэрийн хувьд дотоод, гадаадын гэж ангилах бөгөөд дотоодын ААНБ-ыг хувийн, төрийн, гадаадтай хамтарсан гэж ангилна.

Барилгын ажлын захиалагч гэж барилга байгууламжийн барилгын ажил гүйцэтгүүлэх сонирхол бүхий иргэн, хуулийн этгээд болон тэдгээрийн итгэмжлэгдсэн төлөөлөгч юм.

Туслан гүйцэтгэгч гэж тухайн барилга байгууламж (объект)-ийн тодорхой үе шатны ажилд үндсэн гүйцэтгэгчийн чиг үүргийг хэрэгжүүлэх үүрэг бүхий ААНБ юм. Тухайн объектод хэдэн ч туслан гүйцэтгэгч ажиллаж болно.

Барилгын хөрөнгө оруулагч гэж барилга байгууламжийг барихад шаардагдах хөрөнгийг санхүүжүүлсэн иргэн, хуулийн этгээд юм.

Ашиглалтад оруулсан үндсэн фонд гэж барилга байгууламж, объект баригдаж эхэлснээс хойш дуусах хүртэл хугацаанд хийгдсэн бүх өртгийн нийлбэр дүн юм.

Тайлант оны гүйцэтгэл гэж барилга (объект)-д тухайн оны улирал бүрт хийгдсэн барилга угсралт, их засварын ажлын нийт өртгийн нийлбэр юм.

Барилга эхэлснээс хойших гүйцэтгэл гэж тухайн барилга (объект)-д анх баригдаж эхэлснээс хойш тайлант хугацаа хүртэл хийгдсэн барилга угсралтын бүх ажлын өртгийг нийлбэр юм.

Төсөвт өртөг гэж барилгын зураг төслийн баримт бичгийг үндэслэж тооцсон, барилга барихад шаардагдах нийт мөнгөн хөрөнгийн нийлбэр юм. Төсөвт өртөг нь тухайн барилга (объект) баригдах явцад өөрчлөгдөж болно.

Барилга байгууламжийг засварлах, тоноглох гэж ашиглалтын хэвийн нөхцөлийг дээшлүүлэх зорилгоор барилга байгууламжийг бүхэлд нь буюу хэсэгчлэн засварлаж, нэмэлт болон тусгай тоног төхөөрөмж суурилуулах үйл ажиллагааг ойлгоно.

Барилга байгууламжийг өргөтгөх шинэчлэх гэдэгт барилга байгууламжийн хэмжээг нэмэгдүүлэн үндсэн бүтээц болон инженерийн шугам сүлжээг өөрчлөх, өргөтгөл, шинэчлэл хийх үйл ажиллагааг оруулна. Барилга байгууламж шинээр барих гэдэгт барилга байгууламж барих, эсхүл хуучин барилга байгууламжийг буулгаж барих үйл ажиллагааг ойлгоно.

Бие даасан эх үүсвэр, шугам, сүлжээ гэж тухайн барилга байгууламжийн хэрэгцээг хангахад зориулан барих ус, дулаан, уур, хий, цахилгаан, харилцаа холбоо зэрэг инженерийн хангамжийн шугам сүлжээ, байгууламжийг хамруулж ойлгоно.

Объект гэж бие даасан барилга (орон сууц, үйлдвэрийн гол корпус, сургууль, цех, агуулах) буюу байгууламж (зам, гүүр, далан, суваг, нүхэн гарц) түүнтэй холбогдож хийгдэх үндсэн ба туслах чанарын бусад байгууламж, гадна инженерийн бүх төрлийн шугам сүлжээ, хийц тоноглол, барилгын талбайд хийгдэх өндөржилт, тохижилтын ажлыг хамруулна. Барилга байгууламж, объектын улирлын мэдээнд объект нь нутаг дэвсгэрийн зарчмаар буюу тухайн нутаг дэвсгэрийнхээ барилга угсралт, их засварын ажлын нийт дүнд орж тооцогдоно.

Барилгын материал гэдэгт стандарт, эрүүл ахуй, экологийн шаардлагыг хангасан барилга байгууламжид хэрэглэгдэх эрдэс, түүхий эд, материал, бүтээц, бүтээгдэхүүн, эдлэхүүнийг хамруулж ойлгоно.

ХАМРАХ ХҮРЭЭ

Барилгын салбарын хамрах хүрээ нь Монгол Улсын нутаг дэвсгэрт барилгын чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа өмчийн бүх хэлбэрийн ААНБ байна.

Барилгын салбарт эдийн засгийн бүх төрлийн үйл ажиллагааны салбарын ангилал (ISIC 4.0)-ын дагуу барилга угсралт, барилгын инженерчлэлийн үйл ажиллагаа, барилгын тусгай үйл ажиллагаа гэсэн 3 дэд салбар хамаарна.

Барилга угсралт, их засварын ажлыг тооцохдоо улирал бүрт гүйцэтгэсэн барилга угсралт их засварын ажлын гүйцэтгэлийн нийт дүнгээр тооцдог бөгөөд ашиглалтад оруулсан үндсэн фонд нь барилга байгууламж (объект) баригдаж эхэлснээс хойш дуусах хүртэл хугацаанд зарцуулсан нийт өртгийн хэмжээгээр тодорхойлогдоно.

Барилга байгууламж (объект) нь тайлант онд ашиглалтад орсон бол тухайн тайлант онд хийгдсэн барилга угсралт, их засварын ажлыг тооцохдоо ашиглалтад оруулсан үндсэн фондоос өмнөх онуудад хийгдсэн БУИЗА-ын дүнг хасаж тооцно.

Барилга угсралт, их засварын ажлын бүтцийг тооцохдоо барилга угсралт, их засварын ажлыг төрлөөр нь орон сууцны, орон сууцны бус, инженерийн байгууламж, их засварын ажил гэж ангилна. Төрөл тус бүрийн ажлын өртгийн дүнг нийт дүнд эзлэх хувиар тооцож байна. Барилга угсралт, их засварын ажлын гүйцэтгэлийг тооцох мэдээллийн эх үүсвэр нь бизнес регистрийн санд бүртгэлтэй барилгын салбарт үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгж байгууллагын тайлант хугацаанд гүйцэтгэсэн барилга угсралт, их засварын ажлын хэмжээ болон холбогдох бусад эх үүсвэр буюу БХБЯ-ны ашиглалтад оруулсан барилга, байгууламж, барилга барих эхлүүлэх, үргэлжлүүлэх зөвшөөрөл авсан байгууллагын жагсаалттай тулган шалгах үйл явц болно. Мэдээллийг жилийн болон улирлын давтамжтайгаар цуглуулж холбогдох тооцооллыг хийдэг.

Жилийн давтамжтайгаар: Тайлант хугацаанд статистикийн бизнес регистрийн санд бүртгэлтэй, барилгын салбарын 41-43 дахь дэд салбарт хамаарах үйл ажиллагаа явуулж байгаа ААНБ-ын тооны нийлбэрээр тодорхойлогдоно.

Аж ахуйн нэгж байгууллагын үйл ажиллагааны дэлгэрэнгүй мэдээ, Аж ахуйн нэгж байгууллагын хураангуй мэдээ гэсэн маягтаар тухайн ААНБ-ын орлого, зарлагын дэлгэрэнгүй мэдээллийг цуглуулан барилгын салбарын нэмэгдэл өртгийг тооцож байна.

Жилийн мэдээнд барилгын салбарт далд эдийн засгийн үйл ажиллагааг тооцох зорилгоор барилгын салбарт хувиараа хөдөлмөр эрхлэгчид, иргэдийн үйл ажиллагааг нэмж тооцно.

Улирлын давтамжтайгаар: Тайлант хугацаанд аймаг, нийслэл, сум, дүүргийн нутаг дэвсгэрт баригдаж буй барилга байгууламж, объектын (ББО-1) мэдээг гүйцэтгэгч ААНБ, захиалагч ААНБ-аас тухайн улирлын болон өссөн дүнгээр гүйцэтгэлийг цуглуулдаг. Барилга байгууламж, объектын төрлөөр болон гүйцэтгэгч ААНБ-ын өмчийн хэлбэрээр гүйцэтгэлийг тооцдог.

БАРИЛГЫН САЛБАРЫН ХӨГЖЛИЙН ТҮҮХ

Манай улс барилга, байгууламж тоног төхөөрөмжийн тооллогыг 1926, 1927, 1930 онд хүн ам, малын тооллоготой хамт явуулж байжээ. Хошуу, жасын үл хөдлөх хөрөнгийн 1926 оны тооллогоор 30 гаруй мянган орон байшин тоологдсон байна.

Монголын хувь нийлүүлсэн барилгын хоршоо, хувь нийлүүлсэн "Монгол транс" нийгэмлэгийн харьяанд 1926 онд зам, барилгын ажлыг гүйцэтгэх ерөнхий газар, мал аж ахуйн яамны дэргэд 1929 онд худаг усны хайгуул, барилгын ажлыг эрхэлсэн усан хангамжийн салбар, аж үйлдвэр, барилгын яамны харьяанд 1938 онд барилгын үйлдвэрлэлийг эрхлэн гүйцэтгэх трест, мөн аж ахуйн аргаар барилгын ажил гүйцэтгэгч, захиалагчийн газар 1937 онд байгуулагдсанаар эдгээр салбарт барилгын статистикийн нэгж бий болсон байна.

Барилгын бүртгэлийн ажилд 1960-аад оноос эхлэн ахиц гарч, барилгын захиалагч, гүйцэтгэгч, зураг төсвийн байгууллагын төлөвлөгөөт зорилтын биелэлтэд тогтмол хяналт тавих программын үндсэн дээр зохион байгуулалттай статистик ажиглалтыг явуулах бололцоо, нөхцөл бүрджээ. БНМАУ-ын сайд нарын зөвлөлийн 1961 оны 636 дугаар тогтоолоор барилгын байгууллагын улсын чанартай тайлан мэдээг яам, тусгай газрууд өөрийн системээр нэгтгэж, Тоо бүртгэлийн улсын төв газарт ирүүлж байсан журмыг өөрчлөн, аймаг, хотын статистикийн товчоодоор дамжуулан Тоо бүртгэлийн улсын төв газарт мэдээлж байх журам тогтоосноор нэгдсэн системд орсон.

Төрөөс 1988 оноос их барилга, хөрөнгө оруулалтын салбарт ихээхэн анхаарал хандуулж, төвлөрсөн хөрөнгө оруулалтын гүйцэтгэлд тавих хяналтыг сайжруулах үүднээс олон тооны нарийвчилсан, дэлгэрэнгүй үзүүлэлтээр мэдээлэл цуглуулж, боловсруулалт хийдэг байсан. Тухайлбал: хөрөнгө оруулалт, ашиглалтад оруулсан үндсэн фондын төлөвлөгөөний биелэлтийн жилийн тайлангаар хөрөнгө оруулалтын гүйцэтгэлийг технологийн бүтцээр, улс ардын аж ахуйн салбараар ангилан гаргаж байв.

Монгол Улс ардчилсан зах зээлийн харилцаанд шилжиж, парламентын засаглалтай, ардчилсан нийгмийн байгуулал төлөвшиж, өмчийн олон хэлбэрийн аж ахуйн нэгжүүд бий болсон. 1992 он хүртэл хөрөнгө оруулалтын өсөлт тогтвортой байсан бол 1993 оноос барилга угсралтын ажил, машин тоног төхөөрөмжид оруулсан хөрөнгө оруулалт эрс нэмэгдсэн.

2000 он гарсаар манай улсын эдийн засгийн орчин сайжирч, гадаад, дотоодын хөрөнгө оруулалтын хэмжээ нэмэгдэхийн хэрээр үйлдвэрлэл, үйлчилгээний хэмжээ, үүний дотор барилгын салбарын үйлдвэрлэлийн хэмжээ тогтмол өсөж, барилга угсралт, их засварын ажлын гүйцэтгэл 2000 онд 77.1 тэрбум төгрөг, 2010 онд 463.0 тэрбум төгрөг, 2021 онд 4.5 их наяд төгрөгт хүрээд байна. Мөн 2012 онд төрөөс барилгын салбарыг дэмжих бодлого хөтөлбөр хэрэгжүүлснээр гэр хорооллыг дахин төлөвлөж, хүн амыг орон сууцжуулах ажлыг эхлүүлсэн нь барилгын салбар эрчимтэй өсөхөд нөлөөлж байна.

Төв аймгийн Сэргэлэн сумын нутаг, Хөшигтийн хөндийд ОУНОШБ-ын барилга, түүнийг дагасан бүтээн байгуулалтуудыг 2016 оноос эхлэн барьж 2021 онд ашиглалтад оруулсан.

Өмнөговь, Дорноговь аймгуудад 2019 оноос эхлэн Тавантолгой-Гашуун сухайт чиглэлийн 208.5 км, Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн 414.6 км төмөр замын барилгын томоохон төслүүд хэрэгжиж байна.

БАРИЛГЫН САЛБАРЫН АЖИЛЛАГЧДЫН ТОО, ДУНДАЖ ЦАЛИН, ХӨДӨЛМӨРИЙН БҮТЭЭМЖ 2021

БАРИЛГЫН САЛБАРЫН АЖИЛЛАГЧДЫН ТОО

НИЙТ АЖИЛЛАГЧИД,
мянган хүн



АЖИЛЛАГЧДЫН ДҮНД
ЭЗЛЭХ ХУВЬ

82.2

7.3

БАРИЛГЫН САЛБАРЫН АЖИЛЛАГЧДЫН ДУНДАЖ ЦАЛИН

ДУНДАЖ ЦАЛИН,
мянган төгрөг



ЭМЭГТЭЙ
АЖИЛЛАГЧДЫН ДУНДАЖ
ЦАЛИН мянган төгрөг

1 179.2

1 227.0

БАРИЛГЫН САЛБАРЫН АЖИЛЛАГЧДЫН ХӨДӨЛМӨРИЙН БҮТЭЭМЖ

ХӨДӨЛМӨРИЙН БҮТЭЭМЖ,
улсын хэмжээнд, сая төгрөг



ХӨДӨЛМӨРИЙН БҮТЭЭМЖ,
барилгын салбар, сая төгрөг

22.7

10.0

БАРИЛГЫН САЛБАРЫН АЖИЛЛАГЧДЫН ХӨДӨЛМӨРИЙН БҮТЭЭМЖ

НИЙТ ОСОЛДОГЧИД



ҮҮНЭЭС: ЭМЭГТЭЙ

21


-

I. БАРИЛГЫН САЛБАРЫН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ

I.1 БАРИЛГЫН САЛБАРЫН ЭДИЙН ЗАСАГТ ЭЗЛЭХ БАЙР, СУУРЬ

Монгол улсын дотоодын нийт бүтээгдэхүүн (үйлдвэрлэлийн аргаар тооцсон) 2021 онд оны үнээр 43.6 их наяд төгрөг (15.3 тэрбум америк доллар), 2015 оны зэрэгцүүлэх үнээр 27.1 их наяд төгрөгт хүрч өмнөх оноос 1.6 хувиар өссөн байна. Барилгын салбар нь нийт дотоодын нийт бүтээгдэхүүний 3.7 хувийг эзэлж байна.

ЗУРАГ 1. ДОТООДЫН НИЙТ БҮТЭЭГДЭХҮҮНИЙ САЛБАРЫН БҮТЭЦ




Барилгын салбарын нэмэгдэл өртөг оны үнээр 1.4 их наяд төгрөг, зэрэгцүүлэх үнээр 825.5 тэрбум төгрөгт хүрч, өмнөх оноос оны үнээр 1.3 (0.1%) их наяд төгрөгөөр өссөн бол зэрэгцүүлэх үнээр 244.5 (22.8%) тэрбум төгрөгөөр буурсан байна.

I.2 БАРИЛГЫН САЛБАРЫН АЖ АХУЙН НЭГЖ, БАЙГУУЛЛАГЫН ТОО

Статистикийн бизнес регистрийн санд 2021 онд 230.6 мянган аж ахуйн нэгж, байгууллага бүртгэлтэй байгаагийн 81.5 (35.4%) нь үйл ажиллагаа явуулж байна. Барилгын салбарт 2021 онд 17.5 мянган ААНБ бүртгэлтэй байгаагаас 6.7 (38.1%) мянган ААНБ нь үйл ажиллагаа явуулж байна. Манай улсад үйл ажиллагаа явуулж байгаа нийт ААНБ-ын 8.2 хувь нь барилгын салбарт үйл ажиллагаа явуулж байна.


ЗУРАГ 2. БАРИЛГЫН САЛБАРЫН ААНБ-ЫН ТОО, мянган аанб



Барилгын салбарт үйл ажиллагаа явуулж байгаа ААНБ-ын тоо өмнөх оноос 417 (6.7%) -оор өссөн байна. Тус салбарт төрөөс ипотекийн жилийн 8 хувь, 6 хувийн хүүтэй зээл, орон сууцны үнэ тогтворжуулах хөтөлбөр гэх мэт хүн амыг орон сууцаар хангах бодлогыг хэрэгжүүлсэнтэй холбоотойгоор үйл ажиллагаа явуулж байгаа ААНБ-ын тоо тасралтгүй өссөөр байна.

Барилгын салбарт үйл ажиллагаа явуулж байгаа нийт 6.7 мянган ААНБ-ын 5.5 (83.0%) мянга нь Улаанбаатар хотод, 253 (3.8%) нь баруун бүсэд, 430 (6.4) нь хангайн бүсэд, 296 (5.0%) нь төвийн бүсэд, 106 (1.7%) нь зүүн бүсэд үйл ажиллагаа явуулж байна.

ЗУРАГ 3. БАРИЛГЫН САЛБАРТ ҮЙЛ АЖИЛЛАГАА ЯВУУЛЖ БАЙГАА ААНБ-ЫН БҮСҮҮДЭД ЭЗЛЭХ ХУВЬ



1.3 БАРИЛГЫН САЛБАРТ АЖИЛЛАГЧИД

Улсын хэмжээнд 15 ба түүнээс дээш насны ажиллагчдын тоо 2021 оны байдлаар 1125.6 мянга байгаагийн 82.2 (7.3%) мянга нь барилгын салбарт ажиллаж байна. Барилгын салбарын ажиллагчдын тоо өмнөх оноос 4.9 (6.3%) мянгаар өсжээ. Салбарын ажиллагчдын 17.6 (21.4%) мянган нь эмэгтэй, 64.6 (78.6%) мянган нь эрэгтэй ажиллагч байна.

ХҮСНЭГТ 1. АЖИЛЛАГЧИД, нас, хүйсээр, мянган хүн

| Он | Хүйс | Улсын дүн | Барилга | Насны бүлгээр | | | Нийт ажиллагчдад барилгын салбарт ажиллагчдын эзлэх хувь |
|------|---------|-----------|---------|---------------|-------|-----|--|
| | | | | 15-34 | 35-54 | 55+ | |
| 2021 | Бүгд | 1 125.6 | 82.2 | 36.7 | 40.5 | 5.0 | 7.3 |
| | Эмэгтэй | 532.8 | 17.6 | 5.6 | 11.5 | 0.5 | 3.3 |
| | Эрэгтэй | 592.8 | 64.6 | 31.1 | 29.0 | 4.5 | 10.9 |
| 2020 | Бүгд | 1 162.9 | 77.3 | 37.1 | 36.7 | 3.4 | 6.6 |
| | Эмэгтэй | 551.1 | 11.3 | 4.9 | 6.3 | 0.2 | 2.1 |
| | Эрэгтэй | 611.8 | 66.0 | 32.3 | 30.4 | 3.3 | 10.8 |
| 2019 | Бүгд | 1 146.2 | 68.8 | 33.0 | 31.6 | 4.3 | 6.0 |
| | Эмэгтэй | 539.3 | 12.0 | 4.3 | 7.2 | 0.5 | 2.2 |
| | Эрэгтэй | 606.8 | 56.9 | 28.6 | 24.5 | 3.8 | 9.4 |
| 2018 | Бүгд | 1 253.0 | 76.6 | 37.9 | 35.5 | 3.2 | 6.1 |
| | Эмэгтэй | 583.4 | 13.4 | 5.4 | 7.5 | 0.4 | 2.3 |
| | Эрэгтэй | 669.6 | 63.2 | 32.5 | 28.0 | 2.8 | 9.4 |
| 2017 | Бүгд | 1 238.3 | 70.6 | 34.0 | 34.8 | 1.8 | 5.7 |
| | Эмэгтэй | 585.7 | 13.4 | 5.6 | 7.2 | 0.6 | 2.3 |
| | Эрэгтэй | 652.7 | 57.2 | 28.3 | 27.6 | 1.2 | 8.8 |


Эх үүсвэр: Нийгмийн даатгалын ерөнхий газар

I.4 БАРИЛГЫН САЛБАРТ АЖИЛЛАГЧДЫН ДУНДАЖ ЦАЛИН

Нийгмийн даатгалын ерөнхий газрын нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн 2021 оны тайланд 49.8 мянган ААНБ-ын 840.1 мянган ажиллагчид хамрагдсан байна. Нийт даатгуулагчийн 56.0 (6.7%) мянга нь барилгын салбарт нийгмийн даатгалын шимтгэл төлсөн байна. Барилгын салбарын нийгмийн даатгалын шимтгэл төлөгч даатгуулагчийн тоо өмнөх оноос 1.7 (3.0%) мянгаар буурсан байна.

ААНБ-ын ажиллагчдын сарын дундаж цалин 2021 онд 1279.4 мянган төгрөг болж, өмнөх оноос 58.8 (4.8%) мянган төгрөгөөр, медиан цалин 951.4 мянган төгрөг болж, өмнөх оноос 50.7 (5.6%) мянган төгрөгөөр нэмэгджээ. Барилгын салбарт ажиллагчдын дундаж цалин улсын хэмжээнд 1.2 сая төгрөг болж, өмнөх оноос 46.9 (3.7%) мянган төгрөгөөр буурсан байна. Энэ нь улсын дунджаас 52.4 (4.1%) мянган төгрөгөөр бага байна.

ЗУРАГ 4. БАРИЛГЫН САЛБАРТ АЖИЛЛАГЧДЫН САРЫН ДУНДАЖ ЦАЛИН, мянган төгрөгөөр




Барилгын салбарт ажиллагчдын дундаж цалинг хүйсээр задалж үзвэл, эрэгтэй ажиллагчдын дундаж цалин 1244.5 мянган төгрөг, эмэгтэй ажилчдын дундаж цалин 1179.2 мянган төгрөг байна. Эмэгтэй ажиллагчдын дундаж цалин салбарын дунджаас 47.8 мянган төгрөгөөр доогуур байна.

I.5 БАРИЛГЫН САЛБАРЫН ХӨДӨЛМӨРИЙН БҮТЭЭМЖ

Бүтээмж нь салбарын үр ашигтай байдлыг илэрхийлэх чухал үзүүлэлтийн нэг юм. Барилгын салбарын нэг ажиллагчид ногдох бодит ДНБ, 2021 онд 10.0 сая төгрөг болж, өмнөх оноос 3.8(27.4%) сая төгрөгөөр буурчээ.

ЗУРАГ 5. БАРИЛГЫН САЛБАРЫН ХӨДӨЛМӨРИЙН БҮТЭЭМЖ, 2015 оны зэрэгцүүлэх үнээр, сая төгрөг




Энэ нь улсын түвшнээс 12.7 сая төгрөгөөр доогуур байна. Сүүлийн 5 жилийн хугацаанаас харвал, 2019 онд салбарын нэг ажиллагчид ногдох ДНБ-ий хэмжээ 16.1 сая төгрөг буюу хамгийн өндөр түвшинд хүрсэн байна.

1.6 БАРИЛГЫН САЛБАРЫН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ

Манай улсад 2021 онд нийт 15.9 их наяд төгрөгийн хөрөнгө оруулалт хийгдсэн бөгөөд үүний 928.8 (5.9%) тэрбум төгрөг нь барилгын салбарт хийгджээ. Барилгын салбарт хийгдсэн хөрөнгө оруулалт өмнөх оноос 60.4 (6.1%) тэрбум төгрөгөөр буурчээ.


ЗУРАГ 6. БАРИЛГЫН САЛБАРЫН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ, тэрбум төгрөгөөр



1.7 БАРИЛГЫН САЛБАРЫН ОСОЛ

Барилгын салбарт сүүлийн 5 жилд 134 хүн осолдсон бөгөөд үүний 13 (8.4%) нь эмэгтэйчүүд байна. Мөн сүүлийн 5 жилд үйлдвэрлэлийн ослын улмаас 42 хүн амь насаа алджээ.


ЗУРАГ 7. БАРИЛГЫН САЛБАРТ ОСОЛДСОН ХҮНИЙ ТОО



БАРИЛГА УГСРАЛТ, ИХ ЗАСВАРЫН АЖИЛ, 2021



БАРИЛГА УГСРАЛТ, ИХ ЗАСВАРЫН АЖЛЫН БҮТЭЦ, барилгын төрлөөр



БАРИЛГЫН САЛБАРЫН АЖ АХУЙН НЭГЖ, БАЙГУУЛЛАГЫН ТОО



17 408

Бүртгэлтэй аж ахуйн нэгж байгууллага

7 668

Үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгж байгууллага



19 474.7

мянган м²

Орон сууцны сан¹, сууцны талбайгаар

630 139

тоо


Зөөврийн ус хэрэглэдэг өрх

* Гэрийг оруулаагүй

II. БАРИЛГА УГСРАЛТ ИХ ЗАСВАРЫН АЖЛЫН ГҮЙЦЭТГЭЛ


Барилга угсралт, их засварын ажлын гүйцэтгэл 2021 онд 4.5 их наяд төгрөгт хүрч, өмнөх оноос 695.6 (13.4%) тэрбум төгрөгөөр буурсан байна. Барилга угсралт, их засварын ажлын гүйцэтгэлийн 97.7 хувийг дотоодын, 2.3 хувийг гадаадын барилгын байгууллага гүйцэтгэсэн байна.

ЗУРАГ 8. БАРИЛГА УГСРАЛТ, ИХ ЗАСВАРЫН АЖЛЫН ГҮЙЦЭТГЭЛ, тэрбум төгрөгөөр




Дотоодын барилгын байгууллагууд 2021 онд 4.4 их наяд төгрөгийн барилга угсралт, их засварын ажлыг гүйцэтгэсэн нь өмнөх оноос 685.3 (13.5%) тэрбум төгрөгөөр буурсан байна.

ЗУРАГ 9. ДОТООДЫН БАРИЛГЫН БАЙГУУЛЛАГЫН ГҮЙЦЭТГЭСЭН БАРИЛГА УГСРАЛТ, ИХ ЗАСВАРЫН АЖЛЫН ХЭМЖЭЭ, улирлаар, тэрбум төгрөгөөр



Барилга угсралт, их засварын ажлын гүйцэтгэлийн 568.6 (12.6%) тэрбум төгрөгийг нэгдүгээр улиралд, 1.1 (24.8%) их наяд төгрөгийг хоёрдугаар улиралд, 1.7 (38.4) их наяд төгрөгийг гуравдугаар улиралд, 1.0 (21.9%) их наяд төгрөгийг дөрөвдүгээр улиралд тус тус гүйцэтгэсэн байна. Барилга угсралт, их засварын ажлын дийлэнх нь буюу 63.2 хувийг 2, 3-р улиралд хийж гүйцэтгэсэн байна.

ЗУРАГ 10. ДОТООДЫН БАРИЛГЫН БАЙГУУЛЛАГЫН ГҮЙЦЭТГЭСЭН БАРИЛГА УГСРАЛТ, ИХ ЗАСВАРЫН АЖЛЫН БҮТЭЦ, дүнд эзлэх хувь




Дотоодын барилгын байгууллагын гүйцэтгэсэн барилга угсралт, их засварын ажлын 92.4 хувийг хувийн байгууллага, 6.5 хувийг төрийн өмчийн байгууллага, 1.1 хувийг гадаадтай хамтарсан байгууллага гүйцэтгэсэн байна.

Барилга угсралт, их засварын ажлын гүйцэтгэлийг барилгын төрлөөр авч үзвэл, орон сууцны барилга 35.2 хувийг, орон сууцны

бус барилга 32.6 хувийг, инженерийн байгууламж 29.4 хувийг, их засварын ажил 2.8 хувийг тус тус эзэлж байна.

ЗУРАГ 11. БАРИЛГА УГСРАЛТ, ИХ ЗАСВАРЫН АЖЛЫН БҮТЭЦ, барилгын төрлөөр, дүнд эзлэх хувь




Орон сууцны барилга нийт барилга угсралт, их засварын ажлын 35.2 хувийг эзэлж байгаа нь өмнөх оноос 1.7 нэгж хувиар нэмэгдсэн байна.

Орон сууцны бус барилга нийт барилга угсралт, их засварын ажлын 32.6 хувийг эзэлж байгаа нь өмнөх оноос 1.5 нэгж хувиар буурсан байна.

Инженерийн байгууламжийн ажил барилга угсралт, их засварын ажлын дүнд 29.4 хувийг эзэлж байгаа нь өмнөх оноос 0.2 нэгж хувиар буурсан байна. Харин их засварын ажлын хэмжээ хамгийн бага буюу 2.8 хувийг эзэлж байгаа нь өмнөх оноос өөрчлөлтгүй байна.

Барилга угсралт, их засварын ажлын гүйцэтгэлийг бүсээр хувааж үзвэл Улаанбаатар хотод барилга угсралт, их засварын ажил 41.8 хувийг эзэлж байгаа нь өмнөх оноос 4.2 хувиар, баруун бүсийн аймгуудад 5.2 хувь болж, 0.9 хувиар буурсан ч төвийн бүсийн аймгуудад барилга угсралт, их засварын ажил 41.3 хувь болж, өмнөх оноос 3.0 хувиар, хангай бүсийн аймгуудад 7.4 хувь болж, 1.3 хувиар, зүүн бүсийн аймгуудад 4.4 хувь болж, 0.8 хувиар тус тус өссөн байна. Хот суурин газарт барилга ихээр баригддаг ч сүүлийн жилүүдэд орон нутагт зам, барилга, дэд бүтэц нэмэгдэх хандлагатай байна.

ЗУРАГ 12. БАРИЛГА УГСРАЛТ, ИХ ЗАСВАРЫН АЖЛЫН ГҮЙЦЭТГЭЛ, бүсээр, хувиар



Өмнөговь аймгийн Ханбогд сум дахь Оюу толгойн далд уурхайн бүтээн байгуулалт, Дорноговь аймагт баригдаж буй газрын тос боловсруулах үйлдвэрийг дагасан бүтээн байгуулалтын ажлуудаас хамаарч тус аймгуудад хийгдэж байгаа барилга угсралт, их засварын ажил бусад аймгуудтай харьцуулахад өндөр байна.

2019 - 2021 онд баригдаж ашиглалтад орсон болон баригдаж буй томоохон барилга угсралт, их засварын ажлуудаас дурьдвал:

Улаанбаатар хотод:

- Хөшигтийн хөндийд баригдсан олон улсын нисэх онгоцны шинэ буудлын барилга болон түүнийг дагасан бүтээн байгуулалтууд
- Чингис хааны музейн барилга угсралт
- Хан-Уул дүүрэгт наадам центрийн урд 782 айлын 23 давхар Цэнгэлдэх хотхоны барилгын ажил, 4-н улирлын цэцэрлэг төслийн 1420 айлын Хүннү-2222 хороолол, гэр хорооллын дахин төлөвлөлтийн орон сууцны хорооллууд, зэрэг барилга угсралт, их засварын ажлуудыг гүйцэтгэсэн байна.

Орон нутагт:

- Оюутолгойн далд уурхайн бүтээн байгуулалтууд
- Өмнөговь аймагт Тавантолгой -Гашуун сухайт чиглэлийн 208.5 км, Дорноговь аймагт Зүүнбаян-Тавантолгой хүртэлх 414.6 км төмөр зам

Авто замын ажил: Улсын хэмжээнд явагдаж буй авто замын барилгын томоохон ажлуудаас дурьдвал:

- Хэнтий аймгийн Чингис хотоос Дадал сум (Бэрх) чиглэлийн 70 км хатуу хучилттай автозамын төгсгөл 50 км автозамын ажил
- Хэнтий аймгийн Бор Өндөр сумаас Дорноговь аймгийн Даланжаргалан сум чиглэлийн 50 км хатуу хучилттай авто замын ажил
- Улаанбаатар хотоос Дархан чиглэлийн 204.1 км авто замын ажил

АШИГЛАЛТАД ОРУУЛСАН СУРГУУЛЬ, СОЁЛЫН БАЙГУУЛЛАГА,
мянган суудал



2020
45.3

2021
27.8

АШИГЛАЛТАД ОРУУЛСАН ЭМНЭЛЭГ, орны тоо



1 109

505

АШИГЛАЛТАД ОРУУЛСАН ОРОН СУУЦ, мянган айл



14.2

17.5

АШИГЛАЛТАД ОРУУЛСАН АВТО ЗАМ, км




406.0

213.5

III. АШИГЛАЛТАД ОРУУЛСАН ҮНДСЭН ФОНД

Ашиглалтад оруулсан барилга угсралт, их засварын ажлын өртөг 2021 онд 2.7 их наяд төгрөгт хүрчээ. Нийт өртгийн 1.6 (58.5%) их наяд төгрөгийг орон сууцны барилга, 139.1 (5.2%) тэрбум төгрөгийг худалдаа, үйлчилгээний барилга, 33.0 (1.2%) тэрбум төгрөгийг эмнэлгийн барилга, 313.4 (11.7%) тэрбум төгрөгийг сургууль, соёлын барилга, 165.0 (6.1%) тэрбум төгрөгийг автозам, 58.8 (2.2%) тэрбум төгрөгийг гүүр, гүүрэн гарц, 408.0 (15.2%) тэрбум төгрөгийг бусад төрлийн барилга эзэлж байна.


ЗУРАГ 13. АШИГЛАЛТАД ОРУУЛСАН ҮНДСЭН ФОНД, барилгын төрлөөр, хувиар



III.1 АШИГЛАЛТАД ОРУУЛСАН ОРОН СУУЦНЫ БАРИЛГА

Ашиглалтад оруулсан орон сууцны барилгын ажлын өртөг 2021 онд 1.6 их наяд төгрөг болж, өмнөх оноос 501.2 тэрбум төгрөгөөр өссөн байна. Нийт 17.5 мянган айлын барилгыг ашиглалтад оруулсан нь өмнөх оноос 2.8 мянган айлынхаар өссөн байна.

ЗУРАГ 14. АШИГЛАЛТАД ОРУУЛСАН ОРОН СУУЦ, айлын тоо, өртгөөр




III.1.1 ИПОТЕКИЙН ЗЭЭЛ

Ипотекийн зээлд шинээр хамрагдсан иргэдийн тоо 2021 онд 18.2 мянга болж, өмнөх оноос 8.2 мянган иргэнээр нэмэгдсэн байна. Тухайлбал, 2016 оны сүүлээр ипотекийн 8.0 хувийн зээлийн санхүүжилтийг төрөөс түр хугацаагаар зогсоосон нь барилгын салбарын хөрөнгө оруулалтад нөлөөлж, улмаар барилга угсралт, их засварын ажлын гүйцэтгэл болон ашиглалтад оруулсан орон сууцны тоо буурахад нөлөөлсөн байна. Харин 2020 оны 10 дугаар сараас ипотекийн зээлийн хүү 6.0 хувь болж буурснаар ипотекийн зээлд шинээр хамрагдсан иргэдийн тоо нэмэгдэхэд нөлөөлжээ.


Ипотекийн зээлийн нийт үлдэгдэл 2021 онд 5.7 их наяд төгрөгт хүрч, зээлдэгчийн тоо 104.4 мянга болсон. Үүний 4.3 (76.0%) их наяд төгрөгийг Засгийн газрын орон сууцны ипотекийн зээлийн хөтөлбөрийн хүрээнд олгосон зээл, 1.4 (24.0%) их наяд төгрөгийг хөтөлбөрийн бус зээл эзэлж байна.

ЗУРАГ 15. АШИГЛАЛТАД ОРУУЛСАН ОРОН СУУЦНЫ БАРИЛГА, ИПОТЕКИЙН ЗЭЭЛД ХАМРАГДСАН ИРГЭДИЙН ТОО



Эх үүсвэр: Монголын ипотекийн корпорацийн 2021 оны тайлан

ЗУРАГ 16. АШИГЛАЛТАД ОРУУЛСАН ОРОН СУУЦ, айлын тоогоор, аймгаар



Улсын хэмжээнд 17.5 мянган айлын орон сууц ашиглалтад орсны 14.9 (85.1%) мянга нь Улаанбаатар хотод, 2.6 (14.9%) мянга нь орон нутагт ашиглалтад орсон байна. Ашиглалтад орсон орон сууцны барилгыг аймгуудаар авч үзвэл, Орхон аймагт хамгийн их буюу 535 айлын орон сууц ашиглалтад орсон нь аймгуудад ашиглалтад орсон орон сууцны 20.6 хувийг, Дорнод аймагт 338 айлын орон сууц буюу 13.0 хувийг, Өвөрхангай аймагт 310 айлын орон сууц буюу 11.9 хувийг, Дархан-Уул аймагт 261 айлын орон сууц буюу 10.0 хувийг, бусад аймгуудад ашиглалтад орсон орон сууц 44.5 хувийг эзэлж байна.

III.2 АШИГЛАЛТАД ОРУУЛСАН ОРОН СУУЦНЫ БУС БАРИЛГА

Улсын хэмжээнд 2021 онд 27.8 мянган суудал бүхий сургууль, соёлын барилга ашиглалтад оруулсан бөгөөд үүний 13.0 (46.8%) мянга нь Улаанбаатар хотод, 14.8 (53.2%) мянга нь аймгуудад ашиглалтад оруулсан байна.


ЗУРАГ 17. АШИГЛАЛТАД ОРУУЛСАН СУРГУУЛЬ, СОЁЛЫН БАРИЛГА, суудлаар



Өмнөговь аймагт 1950 суудал бүхий сургууль соёлын барилга ашиглалтад оруулсан нь аймгуудын хэмжээнд хамгийн их бөгөөд Булган аймагт 75 суудал бүхий сургууль соёлын барилга ашиглалтад оруулсан нь хамгийн бага үзүүлэлт болж байна.

Улсын хэмжээнд нийт 505 ор бүхий эмнэлгийн барилга ашиглалтад оруулсан бөгөөд эмнэлгийн орны тоо өмнөх оноос 604 (45.5%)-өөр буурсан байна.

ЗУРАГ 18. АШИГЛАЛТАД ОРУУЛСАН ЭМНЭЛЭГ, орны тоогоор



Тухайлбал: Өвөрхангай аймгийн Арвайхээр хотод 50 ор бүхий хүүхдийн эмнэлэг, 50 ор бүхий уламжлалтын эмнэлэг, 50 ор бүхий хүн эмнэлэг нийт 150 ор бүхий 3 эмнэлэг тус тус ашиглалтад оруулжээ.

Улсын хэмжээнд 213.5 км авто замыг шинээр ашиглалтад оруулсан бөгөөд энэ нь 2020 оноос 192.5 км буюу 47.4 хувиар буурсан байна. Улаанбаатар хотод 65.2 км авто зам ашиглалтад оруулсан бөгөөд улсын хэмжээнд ашиглалтад оруулсан нийт автозамын 30.5 хувийг эзэлж байна.

ЗУРАГ 19. АШИГЛАЛТАД ОРУУЛСАН АВТО ЗАМ, км



Өмнөговь аймагт 62.5 км авто зам ашиглалтад оруулсан нь нийт улсын хэмжээнд ашиглалтад оруулсан авто замын 29.3 хувийг эзлэх бөгөөд үүнд Өмнөговь аймгийн төвийг нийслэлтэй холбосон авто замын "Шар тээг"-ийн уулзвараас Цогтцэций сумын төв хүртэлх 59.6 км хатуу хучилттай авто замын томоохон ажил багтана.

III.3 МОНГОЛ УЛСЫН АВТО ЗАМЫН СҮЛЖЭЭ


Зам тээврийн яамны 2021 оны тайланд тусгаснаар Монгол Улсын авто замын сүлжээний нийт урт 2021 оны байдлаар 112.0 мянган километр. Үүнээс хатуу хучилттай зам 7.7 мянган километр, хайрган хучилттай зам 923.6 мянган километр, сайжруулсан хөрсөн зам 211.9 мянган километр, ердийн хөрсөн зам 6.0 мянган километр байна.

Монгол Улсын авто замын нийт сүлжээнд олон улсын болон улсын чанартай зам 14 918.7 км, орон нутгийн чанартай зам 96125.3 км, тусгай зориулалтын буюу уул уурхайн зориулалттай зам 898.4 км зам эзэлж байна. Олон улсын болон улсын чанартай авто замын 40.5 хувийг ердийн хөрсөн зам, 50.3 хувийг асфальт бетон зам, 6.2 хувийг хайрган зам, 1.4 хувийг сайжруулсан хөрсөн зам, 0.2 хувийг цемент бетон зам эзэлж байгаа бол орон нутгийн чанартай замын 97.7 хувийг ердийн хөрсөн зам, 1.6 хувийг асфальт бетон зам, 0.7 хувийг хайрган болон сайжруулсан хөрсөн зам тус тус эзэлж байна.

Сайжруулсан авто замд хатуу хучилттай, хайрган хучилттай, сайжруулсан хөрсөн замыг хамруулдаг бөгөөд улсын хэмжээнд 2021 оны байдлаар сайжруулсан авто замын урт 12025.5 км-т хүрсэн байна. Үүний 10243.8 км буюу 85.2 хувь нь хатуу хучилттай зам, 1176.8 км буюу 9.8 хувь нь хайрган хучилттай зам, 604.9 км буюу 5.0 хувь нь сайжруулсан хөрсөн зам байгаа бөгөөд өмнөх оноос хатуу хучилттай зам 0.9 хувь буюу 92.8 км-ээр, нэмэгдсэн бол хайрган хучилттай зам 2.6 хувь буюу 31.1 км-ээр буурсан байна. Харин сайжруулсан хөрсөн замын уртад өөрчлөлт ороогүй байна.

Улсын хэмжээнд 2021 онд 1513.5 метр гүүр, гүүрэн гарцыг шинээр ашиглалтад оруулсан нь өмнөх оноос 724.2 (91.8%) метрээр нэмэгдсэн байна. Улаанбаатар хотод 786 метр гүүр, гүүрэн гарц ашиглалтад оруулжээ.

ЗУРАГ 20. АШИГЛАЛТАД ОРУУЛСАН ГҮҮР, ГҮҮРЭН ГАРЦ, метр



Тухайлбал: Баянзүрх дүүргийн 11-р хороо, Туул гол дээгүүрх 321 метр гүүр, Өвөрхангай аймгийн Бат-Өлзий сумын Орхон голын Онгоцтой амны 220 метр төмөр бетон гүүр, Хэнтий аймгийн Биндэр суманд Онон голын дээгүүр 200 метр төмөр бетон гүүр, зэрэг томоохон гүүрний барилгын ажлууд ашиглалтад оруулжээ.

БАРИЛГЫН ЗАРИМ НЭР ТӨРЛИЙН БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ҮЙЛДВЭРЛЭЛ, ИМПОРТ, 2021

ҮЙЛДВЭРЛЭЛ



15.3

Зүсмэл модон матеиал мян.м³

ИМПОРТ

2.7

13.5



Дэр мод мян.м³

6.0

93 625.0



Шохой, тн

583.7

ҮЙЛДВЭРЛЭЛ




Хөнгөн бетон, мян.м³

19.8

Хөөсөнцөр хавтан, мян.м³

37.4

ИМПОРТ



Арматур, Катанка, мян.тн

260.8

Ширмэн радиатор, мян.м³


2 018.5

IV. БАРИЛГЫН ЗАРИМ НЭР ТӨРЛИЙН БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ЗАХ ЗЭЭЛИЙН МЭДЭЭЛЭЛ

IV.1 ЗАРИМ НЭР ТӨРЛИЙН БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ҮЙЛДВЭРЛЭЛ, ИМПОРТ


Манай улс 2021 онд 15.3 мян.м³ барилгын зүсмэл модон материал, 13.5 мян.м³ дэр мод, 93625 тн шохой, 19.8 мян.м³ хөнгөн бетон, 37.4 мян.м³ хөөсөнцөр хавтан үйлдвэрлэсэн байна. Харин 2.7 мян.м³ барилгын зүсмэл модон материал, 6.0 мян.м³ дэр мод, 583.7 тн шохой, 260.8 мян.тн арматур, катанка, 2018.5 мян.м³ ширмэн радиатор импортолсон байна.

ЗУРАГ 21. ЦЕМЕНТИЙН ҮЙЛДВЭРЛЭЛ, ИМПОРТ, мян.тн




Манай улс 2021 онд 1.3 сая.тн цемент үйлдвэрлэж, 4.8 мян.тн-ийг импортолсон байна. Цементийн үйлдвэрлэл өмнөх оноос 111.1 тн буюу 9.4 хувиар нэмэгдсэн бол импорт өмнөх оноос 153.1 тн буюу 97 хувиар буурсан байна.

ЗУРАГ 22. БАРИЛГЫН БЛОКИЙН ҮЙЛДВЭРЛЭЛ, ИМПОРТ, мян.тн



Блок үйлдвэрлэл 2021 онд 195.1 мян.тн, харин импорт 1.8 мян.тн болж блокийн үйлдвэрлэл өмнөх оноос 12.5 мян.тн буюу 6.0 хувиар, импорт 0.8 мян.тн буюу 30.8 хувиар буурсан байна.

ЗУРАГ 23. БАРИЛГЫН ЗАРИМ НЭР ТӨРЛИЙН БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ҮЙЛДВЭРЛЭЛ



Барилгын зарим нэр төрлийн бүтээгдэхүүний 2021 оны үйлдвэрлэлийг гол нэр төрлөөр авч үзвэл, хүрмэн блок 291.3 мянган ширхэг, суурийн блок 195.1 мян.м³, хөнгөн бетон 19.8 мян.м³, улаан тоосго 20.4 сая ширхэг, хөөсөнцөр хавтан 37.4 мян.м³ тус тус үйлдвэрлэжээ.



IV.2 ЗАРИМ НЭР ТӨРЛИЙН БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ҮНЭ

Барилга угсралтын ажилд түгээмэл хэрэглэгддэг зарим нэр төрлийн бүтээгдэхүүний үнийг өмнөх онтой харьцуулж үзвэл, цементийн үнэ 1317.0 (10.9%) төгрөгөөр, ханын цаасны үнэ 7796.0 (59.1%) төгрөгөөр, паркетан шалны үнэ 388 (1.7%) төгрөгөөр, плитаны үнэ 106 (4.9%) төгрөгөөр, вакум цонхны үнэ 11.9 (11.8%) мянган төгрөгөөр, тоосгоны үнэ 7 (2.1%) төгрөгөөр тус тус өссөн бол цагаан тосон будгийн 1 литрийн үнэ 211 (5.0%) төгрөгөөр буурсан байна.

БАРИЛГЫН МАТЕРИАЛЫН ҮНЭ, төгрөг

| | | |
|---|---|------------------------------|
| Тоосго, 50 кг 345.0 |  | Цемент, ш 13 383.0 |
| Паркетан шал, м² 22 846.0 |  | Плита, ш 2 275.0 |
|  | Вакум цонх, м² 112 851.0 | |

ЗУРАГ 24. БАРИЛГЫН ЗАРИМ НЭР ТӨРЛИЙН БАРААНЫ ЖИЛИЙН ДУНДАЖ ҮНЭ



V. ДҮГНЭЛТ

Барилгын салбарын ДНБ-д эзлэх хувь 2021 онд 3.7 хувь болжээ. Мөн тус салбарт бүртгэлтэй 17.5 мянган аж ахуйн нэгж байгаагийн 6.7 мянга буюу 38.1 хувь нь үйл ажиллагаа явуулж байна. Барилгын салбарын ажиллагчдын тоо 82.2 мянгад хүрч өмнөх оноос 4.9 мянга буюу 6.3 хувиар өссөн боловч эдгээр ажиллагчдаас нийгмийн даатгалын шимтгэл төлж буй 56.0 мянган даатгуулагч байна. Тус салбарын ажиллагчдын сарын дундаж цалин 1227.0 мянган төгрөг байгаа нь улсын дунджаас 4.1 хувиар бага байна.

Барилга угсралт, их засварын ажлын гүйцэтгэл 2021 онд 4.5 их наяд төгрөгт хүрч, үүний 32.6 хувийг орон сууцны бус барилга, 35.2 хувийг орон сууцны барилга, 29.4 хувийг инженерийн барилга байгууламж, 2.8 хувийг их засварын ажил тус тус эзэлж байна.

Улсын хэмжээнд 2021 онд 17.5 мянган айл бүхий орон сууцны барилга, 213.5 км урт авто зам, 27.8 мянган суудал бүхий сургууль, соёлын барилга, 505 ор бүхий эмнэлгийн барилга тус тус баригдаж ашиглалтад оруулсан байна. Сургууль, цэцэрлэг, эмнэлгийн болон авто замын барилга угсралтын ажил сүүлийн 5 жилийн хугацаанд өмнөх 5 жилтэй харьцуулахад эрчимтэй өссөн байна.

2013 оноос төрөөс хэрэгжүүлж эхэлсэн ипотекийн жилийн 8 хувийн хүүтэй орон сууцны зээл нь иргэдэд үр өгөөжөө өгч, зээл олгож эхэлснээс хойш 2021 оны байдлаар 104.4 мянган иргэн хамрагдаж, өөрийн эзэмшлийн орон сууцтай болсон байна. Барилга угсралтын ажил эрчимтэй өрнөж байгаагийн дийлэнх хувь нь нийслэл Улаанбаатар хотод явагдаж байгаа бөгөөд үүнийг даган энгийн орон сууцаас гадна чинээлэг хэрэглэгчдэд зориулсан, тэдний хэрэгцээ шаардлагыг хангах тансаг зэрэглэлийн орон сууцууд олноор баригдаж байна. Мөн орон сууцны бус барилга, ялангуяа худалдаа, үйлчилгээний барилга угсралтын ажил эрчимтэй нэмэгдэж байгаа нь барилга угсралтын ажлын бүтцээс тодорхой харагдаж байна.

Төв аймгийн Сэргэлэн сумын нутаг, Хөшигтийн хөндийд ОУНОШБ-ын барилга, түүнийг дагасан бүтээн байгуулалтуудыг 2016 оноос эхлэн барьж 2021 онд ашиглалтад оруулж дууссан бол Өмнөговь, Дорноговь аймгуудад 2019 оноос эхлэн Тавантолгой-Гашуун сухайт чиглэлийн 208.5 км, Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн 414.6 км төмөр замын барилгын томоохон төслүүд үргэлжилж байна.

АШИГЛАСАН МАТЕРИАЛЫН ЖАГСААЛТ

- Барилга байгууламж, объектын улирлын мэдээ, ҮСХ
- Хэрэглээний үнийн сарын мэдээ – 2021 , ҮСХ
- Аж үйлдвэрийн салбарын мэдээ, 2021, ҮСХ
- Тээврийн салбарын танилцуулга, 2021, ҮСХ
- “Монгол Улс 100 жилд” статистикийн эмхэтгэл, 2020, ҮСХ
- Монгол улсын статистикийн эмхэтгэл, 2021, ҮСХ
- Гадаад худалдааны салбарын статистикийн мэдээ – 2021, ҮСХ
- Барилга, хот байгуулалтын яамны цахим сан / www.mcsud.gov.mn/
- Монголын Ипотекийн Корпорацын жилийн тайлан, 2021, МИК /www.mik.mn/
- Монгол банкны цахим сан /www.mongolbank.mn/
- Статистик мэдээллийн нэгдсэн сан /www.1212.mn/
- Зам тээвэр хөжлийн яамны цахим сан /www.mrtd.gov.mn/

ХАВСРАЛТ ХҮСНЭГТҮҮД

ХҮСНЭГТ 1. БАРИЛГЫН САЛБАРЫН ААНБ-ЫН ТОО

| Үзүүлэлт | 2017 | 2018 | 2019 | 2020 | 2021* |
|----------------------------------|--------|--------|--------|--------|--------|
| Бүртгэлтэй ААНБ | 12 806 | 13 623 | 14 687 | 15 858 | 17 522 |
| Үйл ажиллагаа явуулж байгаа ААНБ | 5 400 | 5 736 | 6 099 | 6 258 | 6 675 |

Эх үүсвэр: Статистикийн бизнес регистрийн сан, ҮСХ

ХҮСНЭГТ 2. АЖИЛЛАГЧДЫН ТОО

| Үзүүлэлт | 2017 | 2018 | 2019 | 2020 | 2021* |
|-------------------------------------|-----------|-----------|-----------|-----------|-----------|
| 15 ба түүнээс насны ажиллагчдын тоо | 1 238 333 | 1 253 023 | 1 146 161 | 1 162 912 | 1 125 593 |
| Барилгын салбарт ажиллагчдын тоо | 70 604 | 76 596 | 68 847 | 77 279 | 82 164 |

Эх үүсвэр: Ажиллах хүчний судалгаа, ҮСХ

ХҮСНЭГТ 3. БАРИЛГЫН САЛБАРЫН ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ОСОЛ, хүйсээр, ослын хэлбэрээр

| Үзүүлэлт | 2017 | 2018 | 2019 | 2020 | 2021 |
|---------------------------------------|------|------|------|------|------|
| Осолдогчид | 15 | 17 | 38 | 43 | 21 |
| Эмэгтэй | 3 | 1 | 5 | 2 | - |
| Үйлдвэрлэлийн ослын хэлбэрээр: | | | | | |
| Хөнгөн | 2 | 1 | 10 | 14 | 6 |
| Хүнд | 7 | 12 | 19 | 19 | 9 |
| Нас барсан | 6 | 4 | 9 | 10 | 6 |

Эх үүсвэр: МХЕГ-ын мэдээлэл

ХҮСНЭГТ 4. БАРИЛГЫН САЛБАРЫН НЭМЭГДЭЛ ӨРТӨГ

| Үзүүлэлт | 2015 | 2016 | 2017 | 2018 | 2019 | 2020 | 2021 |
|----------------------------|---------------|-------|-------|-------|---------|---------|---------|
| | тэрбум төгрөг | | | | | | |
| Тайлант оны үнээр | 918.3 | 902.9 | 905.6 | 985.7 | 1 328.9 | 1 367.5 | 1 368.8 |
| 2015 оны зэрэгцүүлэх үнээр | 918.3 | 914.7 | 902.6 | 918.6 | 1 105.3 | 1 070.0 | 825.5 |

ХҮСНЭГТ 5. БАРИЛГА УГСРАЛТ, ИХ ЗАСВАРЫН АЖИЛ, дотоод, гадаадын байгууллагаар

| Үзүүлэлт | 2017 | 2018 | 2019 | 2020 | 2021 |
|--|----------------|----------------|----------------|----------------|----------------|
| | тэрбум төгрөг | | | | |
| Барилга угсралт, их засварын ажил | 3 783.6 | 4 305.6 | 4 869.8 | 5 208.8 | 4 513.2 |
| Дотоодын барилгын байгууллагын гүйцэтгэсэн | 3 255.4 | 3 671.1 | 4 563.7 | 5 094.0 | 4 408.6 |
| Гадаадтай хамтарсан байгууллагын гүйцэтгэсэн | 93.6 | 26.4 | 28.6 | 78.3 | 48.1 |
| Гадаадын байгууллагын гүйцэтгэсэн | 528.2 | 634.5 | 306.1 | 114.9 | 104.6 |

ХҮСНЭГТ 6. БАРИЛГА УГСРАЛТ, ИХ ЗАСВАРЫН АЖЛЫН БҮТЭЦ, барилгын төрлөөр

| Үзүүлэлт | 2017 | 2018 | 2019 | 2020 | 2021 |
|---|-----------------|-------------|-------------|-------------|-------------|
| | Дүнд эзлэх хувь | | | | |
| Барилга угсралт, их засварын ажил-бүгд | 100 | 100 | 100 | 100 | 100 |
| Орон сууцны барилга | 34.8 | 33.4 | 29.0 | 33.5 | 35.2 |
| Орон сууцны бус барилга | 36.3 | 34.9 | 46.4 | 34.1 | 32.6 |
| Үйлдвэрийн | 15.1 | 16.8 | 23.7 | 13.6 | 16.6 |
| Худалдаа, үйлчилгээний | 8.1 | 4.9 | 2.8 | 2.8 | 2.8 |
| Эмнэлэг, сургууль, соёлын | 7.8 | 8.1 | 13.3 | 11.5 | 8.6 |
| Бусад | 5.3 | 5.1 | 6.6 | 6.2 | 4.6 |
| Инженерийн байгууламж | 26.6 | 29.5 | 22.2 | 29.6 | 29.4 |
| Эрчим хүчний | 4.7 | 11.8 | 3.8 | 1.0 | 0.6 |
| Холбооны | 0.3 | 0.2 | 0.0 | 0.0 | 0.0 |
| Төмөр зам | - | 0.8 | 1.2 | 16.1 | 19.0 |
| Авто зам | 14.3 | 10.8 | 11.9 | 8.3 | 6.3 |
| Гүүр, гүүрэн гарц | 1.5 | 2.7 | 2.1 | 0.3 | 0.5 |
| Далан, суваг, шугам, сүлжээ | 2.2 | 2.1 | 2.2 | 2.3 | 1.7 |
| Бусад(зам, талбайн бусад ажил) | 3.7 | 1.1 | 1.1 | 1.6 | 1.2 |
| Их засварын ажил | 2.3 | 2.2 | 2.4 | 2.8 | 2.8 |

ХҮСНЭГТ 7. ДОТООДЫН БАРИЛГЫН БАЙГУУЛЛАГЫН ГҮЙЦЭТГЭСЭН БАРИЛГА УГСРАЛТ, ИХ ЗАСВАРЫН АЖИЛ, бүс, аймаг, нийслэлээр

| Үзүүлэлт | 2017 | 2018 | 2019 | 2020 | 2021 |
|--------------------|----------------|----------------|----------------|----------------|----------------|
| | тэрбум төгрөг | | | | |
| Бүгд | 3 255.4 | 3 671.1 | 4 563.7 | 5 094.0 | 4 408.6 |
| Баруун бүс | 91.4 | 203.5 | 388.6 | 290.8 | 220.8 |
| Баян-Өлгий | 8.8 | 22.1 | 29.5 | 33.6 | 27.7 |
| Говь-Алтай | 9.9 | 22.8 | 69.2 | 121.9 | 25.0 |
| Завхан | 52.3 | 117.5 | 192.0 | 36.7 | 22.3 |
| Увс | 10.1 | 24.1 | 55.2 | 53.3 | 26.5 |
| Ховд | 10.3 | 17.0 | 42.7 | 45.2 | 119.3 |
| Хангайн бүс | 144.9 | 198.5 | 310.3 | 319.1 | 322.5 |
| Архангай | 10.9 | 12.5 | 46.8 | 58.4 | 39.7 |
| Баянхонгор | 27.1 | 35.8 | 62.3 | 33.4 | 29.5 |
| Булган | 20.9 | 7.9 | 11.0 | 18.5 | 12.5 |
| Орхон | 36.6 | 74.4 | 8.6 | 120.3 | 126.6 |
| Өвөрхангай | 30.1 | 34.3 | 68.4 | 53.0 | 61.1 |
| Хөвсгөл | 19.4 | 33.6 | 39.2 | 35.6 | 53.2 |
| Төвийн бүс | 1 084.4 | 1 242.0 | 1 672.8 | 1 964.0 | 1 839.2 |
| Говьсүмбэр | 4.0 | 3.4 | 14.6 | 8.0 | 4.6 |
| Дархан-Уул | 39.5 | 91.1 | 101.5 | 95.7 | 92.7 |
| Дорноговь | 97.2 | 137.5 | 155.5 | 537.3 | 284.3 |
| Дундговь | 8.0 | 131.1 | 146.2 | 25.7 | 32.7 |
| Өмнөговь | 562.7 | 732.7 | 1 135.4 | 1 100.4 | 1 362.2 |
| Сэлэнгэ | 90.5 | 13.2 | 35.3 | 68.5 | 25.8 |
| Төв | 282.6 | 132.9 | 84.5 | 128.5 | 36.9 |
| Зүүн бүс | 39.5 | 58.6 | 149.2 | 181.7 | 176.5 |
| Дорнод | 12.5 | 23.7 | 54.4 | 27.7 | 54.5 |
| Сүхбаатар | 8.0 | 20.9 | 29.2 | 33.5 | 25.5 |
| Хэнтий | 18.9 | 14.0 | 65.7 | 120.5 | 96.5 |
| Улаанбаатар | 1 895.3 | 1 968.5 | 2 042.8 | 2 338.4 | 1 849.6 |

ХҮСНЭГТ 8. АШИГЛАЛТАД ОРУУЛСАН ҮНДСЭН ФОНД, барилгын төрлөөр

| Үзүүлэлт | 2017 | 2018 | 2019 | 2020 | 2021* |
|--------------------------------|----------------|----------------|----------------|----------------|----------------|
| | тэрбум.төг | | | | |
| Бүгд | 2 572.9 | 4 050.4 | 3 594.9 | 2 761.2 | 2 689.2 |
| Орон сууцны | 1 280.9 | 973.5 | 1 183.3 | 1 070.7 | 1 571.9 |
| Худалдаа, үйлчилгээний барилга | 164.5 | 638.7 | 120.7 | 80.8 | 139.1 |
| Эмнэлгийн | 28.8 | 28.0 | 117.7 | 119.9 | 33.0 |
| Сургууль, соёлын | 243.1 | 232.8 | 320.5 | 413.1 | 313.4 |
| Авто зам | 156.5 | 355.0 | 971.0 | 318.4 | 166.3 |
| Гүүр, гүүрэн гарц | 21.0 | 41.3 | 25.4 | 84.0 | 58.8 |
| Бусад | 678.0 | 1 781.0 | 856.3 | 674.2 | 406.8 |

ХҮСНЭГТ 9. АШИГЛАЛТАД ОРУУЛСАН ҮНДСЭН ХӨРӨНГӨ, барилгын төрөл, хүчин чадлаар

| Он | 2017 | 2018 | 2019 | 2020 | 2021* |
|---------------------------------------|--------|--------|--------|--------|---------|
| Орон сууцны барилга, айлын тоо | 18 685 | 12 824 | 15 988 | 14 165 | 17 478 |
| Эмнэлэг, орны тоо | 534 | 616 | 942 | 1 379 | 505 |
| Сургууль, соёлын барилга, суудлын тоо | 19 063 | 16 460 | 26 177 | 48 946 | 27 839 |
| Авто зам, км | 376.6 | 442.4 | 891.7 | 410.3 | 213.5 |
| Гүүр, гүүрэн гарц, метр | 740.4 | 481.8 | 1231.2 | 789.3 | 1 513.5 |

ХҮСНЭГТ 10. БАРИЛГЫН ЗАРИМ НЭР ТӨРЛИЙН БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ҮЙЛДВЭРЛЭЛ

| Он | Цемент, мян.тонн | Бетон зуурмаг мян.м ³ | Шохой мян.тонн | Хөнгөн бетон, мян.м ³ | Суурийн блок мян.м ³ | Хүрмэн блок мян.ш | Улаан тоосго мян.ш | Хөөсөнцөр хавтан, мян.м ³ |
|-------|------------------|----------------------------------|----------------|----------------------------------|---------------------------------|-------------------|--------------------|--------------------------------------|
| 2017 | 675.2 | 102.5 | 56.2 | 3.4 | 91.5 | 252.1 | 22 963.4 | 31.4 |
| 2018 | 933.8 | 170.7 | 58.7 | 4.3 | 179.1 | 305.9 | 28 923.3 | 42.8 |
| 2019 | 1 098.0 | 377.9 | 77.3 | 5.5 | 196.9 | 298.3 | 26522.0 | 48.7 |
| 2020 | 1 182.2 | 274.2 | 70.2 | 7.0 | 207.6 | 111.8 | 19912.1 | 33.2 |
| 2021* | 1 293.3 | 607.9 | 93.6 | 19.8 | 195.1 | 291.3 | 20394.5 | 37.4 |

Эх үүсвэр: Аж үйлдвэрийн салбарын танилцуулга - 2021, ҮСХ

ХҮСНЭГТ 21. БАРИЛГЫН ЗАРИМ НЭР ТӨРЛИЙН БАРААНЫ ИМПОРТ

| Он | Цемент, мян.тонн | Цонхны шил, мян.м ² | Ширмэн радиатор, тонн | Арматур, катанка, мян.тонн | Галт тэсвэртэй тоосго, блок, хавтан, тонн | Харцаас, тонн | Зүсмэл модон материал /Банз/ мян.м ³ | Барилгын блок, м ³ |
|-------|------------------|--------------------------------|-----------------------|----------------------------|---|---------------|---|-------------------------------|
| 2017 | 35.8 | 1 443.2 | 312.6 | 104.2 | 3 544.2 | 9 178.9 | 39 891.1 | - |
| 2018 | 35.8 | 2 379.6 | 745.4 | 191.8 | 4 231.2 | 13 767.8 | 1 893.4 | 6 398.8 |
| 2019 | 44.3 | 3 292.6 | 929.9 | 229.6 | 4 711.6 | 17 679.5 | 1 817.8 | 7 982.4 |
| 2020 | 315.8 | 4 433.2 | 1 591.1 | 208.6 | 1 301.3 | 26 383.5 | 1 949.7 | 2 550.5 |
| 2021* | 4.7 | 1 777.5 | 2 018.5 | 260.8 | 1 301.3 | 26 383.5 | 2 717.0 | 1 772.3 |

Эх үүсвэр: ГЕГ-ын импортын мэдээлэл

ХҮСНЭГТ 32. БАРИЛГЫН ЗАРИМ НЭР ТӨРЛИЙН БАРААНЫ ЖИЛИЙН ДУНДАЖ ҮНЭ

| Материалын нэр | 2017 | 2018 | 2019 | 2020 | 2021 | 2021% 2020 |
|-----------------------------------|-----------|--------|--------|---------|---------|---------------|
| | төгрөгөөр | | | | | |
| Ханын цаас, боодол, БНСУ | 11 707 | 10 000 | 11 526 | 13 198 | 20 994 | 59.1 |
| Цагаан тосон будаг, 1 литр, БНХАУ | 3 596 | 3 876 | 3 979 | 4 253 | 4 042 | -5.0 |
| Плита, ширхэг, БНХАУ | 1 659 | 1 748 | 2 033 | 2 169 | 2 275 | 4.9 |
| Цемент, 50 кг, БНХАУ | 9 712 | 9 251 | 10 263 | 12 066 | 13 383 | 10.9 |
| Тоосго, ширхэг, дотоодын | 296 | 261 | 326 | 338 | 345 | 2.1 |
| Вакум цонх, 1 м2 | 85 410 | 84 134 | 90 120 | 100 908 | 112 851 | 11.8 |
| Паркетан шал, 1 м2, БНХАУ | 21 861 | 22 340 | 22 458 | 22 458 | 22 846 | 1.7 |

Эх үүсвэр: Хэрэглээний үнийн сарын мэдээ, ҮСХ